

ҮЛ ХӨДЛӨХ ЭД ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага /цаашид ҮХЭХЗБ гэх/-ын үйл ажиллагаа, санхүүгийн байдалд хяналт шалгалт хийж, холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас баталсан журмын хэрэгжилт, санхүү, төлбөрийн чадвар, үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийн түвшинг тодорхойлон үнэлгээ, дүгнэлт өгч, илэрсэн зөрчил дутагдалд холбогдох арга хэмжээ авахад оршино.

1.2. Энэ журамд заасан хяналт шалгалтын удирдамжийг Санхүүгийн зохицуулах хорооны дарга батална.

1.3. Монголбанк болон холбогдох төрийн байгууллагуудтай хамтран нэгдсэн хяналт шалгалтыг хийхэд энэ журмыг баримталж болно.

Хоёр. Хяналтын төрөл, хэлбэр

2.1. Санхүүгийн зохицуулах хороо ҮХЭХЗБ-д холбогдох хууль, тогтоомж, дүрэм, журмыг хэрхэн хэрэгжүүлж байгаад тавих хяналт шалгалт нь дараах төрөлтэй байна:

2.1.1. Зайны хяналт шалгалт

2.1.2. Газар дээрх хяналт шалгалт

2.2 Газар дээрх хяналт шалгалт дараах хэлбэртэй байна:

2.3.1. Төлөвлөгөөт хяналт шалгалт

2.3.2 Төлөвлөгөөт бус хяналт шалгалт

2.4. Зайны болон газар дээрх хяналт шалгалтыг хянан шалгагч, улсын байцаагч хэрэгжүүлнэ. Газар дээрх хяналт шалгалтыг зөвхөн улсын байцаагчийн эрхтэй хянан шалгагч, улсын байцаагч дангаараа хэрэгжүүлэх буюу эсвэл ажлын хэсгийг удирдана.

2.5. Хянан шалгагч, улсын байцаагч нь Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, бусад хууль, Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагчийн дүрэм болон энэ журмын хүрээнд хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ

Гурав. Зайны хяналт шалгалт явуулах ажиллагаа

3.1. зайны хяналт шалгалтыг Санхүүгийн зохицуулах хорооны хяналт шалгалт хийх чиг үүрэг бүхий нэгж хийнэ.

3.2. ҮХЭХЗБ-д байнгын хяналт шалгалтыг энэ журмын хавсралт ... -ын дагуу сар бүр цахим хэлбэрээр, хавсралт ... дагуу улирал бүр ирүүлэх санхүүгийн тайлан, мэдээг дараа улирал эхний сарын 10-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

3.3.Зайны хяналт шалгалт явуулахад дараах тайлан мэдээг ашиглана:

3.3.1. “..... маягт”,

3.3.2. үйл ажиллагааны улирлын тайлан, мэдээ

3.3.3. Сар бүрийн зуучлалын арилжааны мэдээ

3.3.4. Өмнө хийж гүйцэтгэсэн газар дээрх болон зайны хяналт шалгалтын тайлан

3.3.5. Өмнө хийж гүйцэтгэсэн газар дээрх болон зайны хяналт шалгалтаар өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийн тайлан.

3.3. Энэ журмын 3.3.4, 3.3.5-д заасан үндэслэлээр газар дээрх хяналт шалгалт явуулах эсэхийг холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлнэ.

3.4. Зайны хяналт шалгалтын явцад ҮХЭХЗБ-аас нэмэлт мэдээлэл авах, тайлбар гаргуулахаар хандаж болно.

3.5.Зайны хяналт шалгалтын ажилд шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Санхүүгийн зохицуулах хороо хяналт шалгалт хийгдэж буй ҮХЭХЗБ-ын талаарх мэдээ, мэдээллийг авах хүсэлтийг хуульд заасан журмын дагуу дотоодын болон гадаадын бусад эрх бүхий байгууллагуудад тавьж болно.

Дөрөв.Газар дээрх хяналт шалгалт явуулах үндэслэл

4.1.Санхүүгийн зохицуулах хороо ҮХЭХЗБ нь холбогдох хууль, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгааг тогтоох зорилгоор газар дээрх хяналт шалгалтыг хийнэ.

4.2.Газар дээрх хяналт шалгалтыг дараах үндэслэлээр хийж болно:

4.2.1.Энэ журмын 3.3-д заасан үндэслэл

4.2.2. Зайны хяналт шалгалтын дүгнэлтэд заасан үндэслэл

Тав.Хяналт шалгалт хийх бэлтгэл

5.1.Газар дээрх хяналт шалгалтыг хийхийн өмнө тухайн шалгалтын хамрах хүрээ, үнэлэх үзүүлэлтийг харгалзан дараах баримт, мэдээлэлтэй танилцана.

5.1.1. Энэ журмын 6.2-т заасан үндэслэл, тэдгээртэй холбоотой материал

5.1.2. Өмнө хийгдсэн хяналт шалгалтын материал, тайлан

5.1.3. Өмнө хийгдсэн хяналт шалгалтаар өгсөн үүрэг, даалгаврын биелэлт

5.1.4. ҮХЭХЗБ-ын үйл ажиллагаанд хөндлөнгийн байгууллагын хийсэн аудитын дүгнэлт

5.1.6. ҮХЭХЗБ-ын боловсруулсан дотоод бодлого, дүрэм, журам, тэдгээрт орсон өөрчлөлт

5.1.7. Бусад

5.2.Төлөвлөгөөт хяналт шалгалтыг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан жилийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсан газар дээрх хяналт шалгалтын хуваарийн дагуу хийнэ.

5.3.Төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг удирдамжийг батлуулж, шалгалтад хамрагдах байгууллагад танилцуулснаас хойш ажлын 3 хоногийн дараа шалгалтыг эхлүүлж болно.

5.4. ҮХЭХЗБ-д газар дээрх хяналт шалгалт хийхийн өмнө шалгалтын удирдамж, урьдчилан бэлтгэх баримт, материалын жагсаалтыг ҮХЭХЗБ-ын удирдлагад танилцуулж, гардуулж өгнө.

5.5.Газар дээрх хянан шалгалтын удирдамжид нэр нь дурдагдаагүй хянан шалгагч, улсын байцаагч, эрх бүхий албан тушаалтан газар дээрх хяналт шалгалтад оролцохыг хориглоно.

Зургаа. Газар дээрх хяналт шалгалт явуулах ажиллагаа

6.1. Санхүүгийн зохицуулах хороо ҮХЭХЗБ нь холбогдох хууль, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, хүлээсэн үүргээ хэрхэн биелүүлж байгааг тогтоох зорилгоор газар дээрх хяналт, шалгалтыг хийнэ.

6.2. Иж бүрэн хяналт шалгалтыг Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан хуваарийн дагуу хийнэ.

6.3. Хэсэгчилсэн шалгалт нь шалгалтын удирдамжийг батлуулж, шалгалтад хамрагдах ҮХЭХЗБ-д танилцуулснаар шалгалтыг эхлүүлнэ.

6.4. Хяналт шалгалтад хамрагдах ҮХЭХЗБ-ээс дараах тайлан мэдээ, холбогдох баримт бичгүүдийг шаардана:

6.4.1. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, хавсралт, компанийн дүрэм;

6.4.2., Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг зохицуулсан журам болон холбогдох бусад дүрэм, журмууд;

6.4.3. Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд орсон өөрчлөлт, холбогдох баримт бичиг, удирдлага зохион байгуулалтын талаарх мэдээлэл;

6.4.4. Зайны болон газар дээрх хяналт шалгалтаар өгсөн үүрэг даалгаврын биелэлт, холбогдох баримт бичиг;

6.4.5. Санхүүгийн тайлан болон холбогдох тайлан мэдээ;

6.4.6. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтан томилсон шийдвэр;

6.4.7. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасан дотоод хяналтын хөтөлбөр, эрсдэлийн удирдлагын хөтөлбөр;

6.4.8. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн дагуу 20 сая төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээ, сэжигтэй гүйлгээний тухай мэдээллийг хуульд заасан хугацаанд Монголбанкны Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлсэн талаарх баримт;

6.4.9. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан харилцагчийг таньж мэдэх үүргээ биелүүлсэн талаарх баримт бичиг;

6.4.10. Холбогдох бусад баримт бичиг.

6.5. Энэ журмын 1.4.1, 1.4.2-д заасан этгээд нь хувь хүн бол түүнд энэ журмын 4.4.1 дэх заалт хамаарахгүй байж болно.

6.6. Шалгалтын тайланд дараах мэдээллийг тусгана:

6.6.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, хяналт болон шаардлагатай гэж үзсэн бусад асуудлын талаархи дүгнэлт;

6.6.2. Тайлантай холбогдуулан тусгай зөвшөөрөл эзэмшигчээс хариу шаардах, хариу шаардаагүй бол онцгойлон анхаарах асуудал.

6.7. Ажлын хэсэг шалгалтад хамрагдсан ҮХЭХЗБ-ийн удирдлагад үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн байдалд өгсөн дүгнэлт болон шалгалтын акт, материалыг танилцуулна.

6.8. Шалгалтын тайлантай холбогдуулан хариу шаардсан бол тусгай зөвшөөрөл эзэмшигч тайланг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 14 хоногийн дотор, эсхүл тайланд тусгайлан заасан хугацаанд Хороонд хариу мэдэгдэх үүрэгтэй.

6.9. Шалгалтаар өгсөн дүгнэлтийг тухайн ҮХЭХЗБ хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд дүгнэлттэй танилцсанаас хойш 10 хоногийн дотор Хорооны Улсын Ерөнхий байцаагчид бичгээр гомдол гаргаж болно.

Долоо. Тэмдэглэл үйлдэх

7.1.Энэ журамд заасан хяналт шалгалтын ажиллагаа явуулах замаар цуглуулсан баримт, материалыг тэмдэглэлд тусгаж бэхжүүлнэ.

7.2.Хянан шалгагч, улсын байцаагч тэмдэглэл үйлдэхийн зэрэгцээ мэдээллийг тусгасан дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг хийх, гэрэл зураг авах аргыг хэрэглэж болно.

7.3.Хянан шалгагч, улсын байцаагч цугларсан баримт, материалыг устгах, гэмтэх, үрэгдэхээс хамгаалах арга хэмжээг авна.

Найм. Хяналт шалгалтын тайлан

8.1.Газар дээрх хяналт шалгалтын ажлыг хийж дууссаны дараа улсын байцаагч нар шалгалтаар илэрсэн нөхцөл байдал, алдаа дутагдал,тэдгээрийг нотлох баримт, дүгнэлт зэргийг багтаасан дэлгэрэнгүй тайлан боловсруулж гаргана. Тайланд дараах мэдээллүүд багтсан байна. Үүнд:

8.1.1.Хяналт шалгалт явуулах үндэслэл, хамрах хүрээ, хяналт шалгалт хийсэн хугацаа;

8.1.2.Хяналт шалгалтад хамрагдсан этгээд, түүний хууль ёсны итгэмжлэгдсэн төлөөлөгч, хяналт шалгалтын үйл ажиллагааг гүйцэтгэсэн улсын байцаагч нарын нэрс;

8.1.3.Хяналт шалгалтад хамрагдсан ҮХЭХЗБ-ын үйл ажиллагаанд холбогдуулан цуглуулсан мэдээлэлд хийсэн дүгнэлт;

8.1.4.Шалгалтын явцад илэрсэн бусад алдаа дутагдал;

8.1.5.Илэрсэн алдаа, дутагдал, тэдгээрийг нотлох баримт

8.1.6.Нэгдсэн үнэлгээ;

8.1.7.Зөвлөмж болон санал болгосон арга хэмжээ.

8.1.8. Бусад

Ес. Хяналт шалгалтын дүгнэлтийг танилцуулах

9.1 Хяналт шалгалт дууссанаас хойш ажлын таван өдөрт багтааж хяналт шалгалтын дүгнэлтийг Санхүүгийн зохицуулах хорооны даргад танилцуулна.

9.2 Хяналт шалгалтын дүгнэлт нь дараах мэдээллийг агуулсан байна:

9.2.1.Тухайн ҮХЭХЗБ-д хийгдсэн хяналт шалгалтын чиглэл, арга, хамрагдсан хүрээ, хяналт шалгалтыг хийсэн огноо.

9.2.2.Улсын байцаагчийн актад хууль тогтоомж зөрчигдсөнийг нотлох баримтыг хавсаргасан байна.

9.2.3.Тухайн мҮХЭХЗБ-ын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэгдсэн дотоод журмынх нь хэрэгжилтэд үнэлэлт, дүгнэлт хийсэн байна.

9.2.4.Шалгалтын явцад газар дээр нь шууд засч залруулж болох алдаа, дутагдалыг залруулах шуурхай арга хэмжээ авсан бол тэмдэглэл хийсэн байна.

9.2.5.Шалгалтын явцад санал гомдол хүлээн авсан, харъяаллын дагуу хэрхэн шийдвэрлэсэн.

9.2.6.Өмнөх шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгах талаар өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийн талаар нотлох баримттай дүгнэлт өгсөн байна.

9.3 Шалгалтын дүнг ҮХЭХЗБ нь хүлээн зөвшөөрөхгүй тохиолдолд шалгалтын дүгнэлт эсхүл мэдэгдэлтэй танилцсанаас хойш ажлын 14 хоногийн дотор Санхүүгийн зохицуулах хорооны даргад бичгээр гомдол гаргаж болно.

9.4 Шалгалтын дүгнэлт, холбогдох материалыг тухайн ҮХЭХЗБ-ын хувийн хэрэгт хавсаргана.

Арав. Бусад

10.1.Шалгалтын явцад Санхүүгийн зохицуулах хорооны улсын байцаагч, хянан шалгагч нь холбогдох хууль тогтоомж болон энэ журмыг зөрчсөн тухай гомдлыг хяналт шалгалтад хамрагдаж байгаа ҮХЭХЗБ нь Хорооны удирдлагад гомдол гаргаж болно.

10.2. Энэхүү журмыг зөрчсөн иргэн, хуулийн этгээд, албан тушаалтанд Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Зөрчлийн тухай хуульд заасны дагуу захиргааны хариуцлага хүлээлгэнэ.